



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хотонт сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/38/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a> Архангай аймаг 2025 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: <a href="mailto:Baigalmaat@audit.gov.mn">Baigalmaat@audit.gov.mn</a> Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: <a href="mailto:Nerguibaatard@audit.gov.mn">Nerguibaatard@audit.gov.mn</a> Аудитор В.Цогжаргал Утас: 99158257 Цахим хаяг: <a href="mailto:Tsoqjargalb@audit.gov.mn">Tsoqjargalb@audit.gov.mn</a></p>
------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhantai@audit.gov.mn

2025.02.14 № 06

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХОТОНТ СУМЫН ИТХ-ЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА М.ЭНХЧИМЭГ ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хотонт сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа зөрчлийн нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Хотонт сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлаас 14,000.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 402 дугаар тушаалаар баталсан "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн сонгууль зохион байгуулагдаж сумын ИТХ-д шинээр 21 хурлын төлөөлөгч сонгогдон ажиллаж байна.

#### Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвөөс **198,162.2** мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 178,081.9 мянган төгрөгийг зарцуулж, 20,080.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нь цалингийн сангийн төлөвлөлттэй холбоотой байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 7 зорилт 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсний 20 арга хэмжээ нь дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн үр дүндээ хүрсэн, 7 арга хэмжээ 80-89 хувь, 1 арга хэмжээ 60 хувийн гүйцэтгэлийг сумын ИТХ-ын даргаас 83.9 хувиар үнэлсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,382,000.00	782,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,382,000.00	782,000.00
354	Хангамжийн материал	1,382,000.00	782,000.00
3541	Бичиг хэргийн материал	1,295,000.00	695,000.00
3542	Аж ахуйн материал	87,000.00	87,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,101,877.80	5,715,495.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,101,877.80	5,715,495.05
392	Биет хөрөнгө	6,101,877.80	5,715,495.05
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,031,134.00	10,631,134.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,785,525.49	-6,647,812.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,696,580.00	4,696,580.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,840,310.71	-2,964,406.56
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,483,877.80	6,497,495.05
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,483,877.80	6,497,495.05
51	Засгийн газрын хувь оролцоо	7,483,877.80	6,497,495.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,234,000.00	2,234,000.00
51101	Өмч: - төрийн	2,234,000.00	2,234,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	5,174,613.76	4,188,231.01
5121	Өмнөх үеийн үр дүн	5,174,613.76	5,174,613.76
5122	Тайлант үеийн үр дүн	0.00	-986,382.75
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	75,264.04	75,264.04
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,483,877.80	6,497,495.05

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	125,685,800.00	198,762,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	600,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	600,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	600,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	125,685,800.00	198,162,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	125,685,800.00	198,162,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	125,685,800.00	198,162,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	126,644,892.10	199,148,582.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	126,644,892.10	199,148,582.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,282,931.91	155,758,284.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	76,103,450.40	123,788,371.28
210101	Үндсэн цалин	58,137,318.19	76,183,636.36
210102	Нэмэгдэл	12,529,105.00	42,685,234.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,593,042.48	0.00
210104	Урамшуулал	3,843,984.73	4,919,500.00

**Архангай аймгийн Хотонт сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,915,527.90	15,446,020.05
210201	Тэтгэврийн даатгал	6,068,338.39	10,516,564.64
210202	Тэтгэмжийн даатгал	713,922.15	1,229,216.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	571,137.71	943,487.35
210204	Ажилгүйдлийн даатгал	134,284.50	282,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,427,845.15	2,474,251.57
2104	Хангамж, бараа материалын зардал	5,981,200.00	13,063,800.00
210401	Бичиг хэрэг	1,773,800.00	3,064,988.00
210402	Тээвэр, шатахуун	4,207,400.00	9,710,012.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		288,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,213,000.00	574,000.00
210604	Урсгал засвар	1,213,000.00	574,000.00
2107	Томилолт, зочны зардал	774,800.00	703,600.00
210702	Дотоод албан томилолт	774,800.00	703,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	161,100.00	96,110.00
210803	Даатгалын үйлчилгээ	71,100.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	50,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	46,110.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,133,853.61	2,086,382.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	437,761.51	1,100,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,696,092.10	986,382.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,361,960.19	43,390,298.67
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	19,855,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	19,855,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,000,000.00	3,455,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	660,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,000,000.00	2,795,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,361,960.19	20,080,298.67
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,361,960.19	20,080,298.67
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-959,092.10	-386,382.75
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	600,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	600,000.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-600,000.00
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-959,092.10	-986,382.75

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	125,685,800.00	198,162,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	125,685,800.00	198,162,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	125,685,800.00	198,162,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	125,685,800.00	198,162,200.00

Архангай аймгийн Хотонт сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	125,685,800.00	198,162,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	125,685,800.00	198,162,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	93,323,839.81	152,741,901.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	75,067,450.40	123,644,171.28
210101	Үндсэн цалин	51,705,979.49	76,039,436.36
210102	Нэмэгдэл	17,924,443.70	42,685,234.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,593,042.48	0.00
210104	Урамшуулал	3,843,984.73	4,919,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,915,527.90	15,446,020.05
210201	Тэтгэврийн даатгал	6,068,338.39	10,516,564.64
210202	Тэтгэмжийн даатгал	713,922.15	1,229,216.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	571,137.71	943,487.35
210204	Ажилгүйдлийн даатгал	134,284.50	282,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,427,845.15	2,474,251.57
2104	Хангамж, бараа материалын зардал	6,017,200.00	6,902,000.00
210401	Бичиг хэрэг	2,217,200.00	2,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,800,000.00	3,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		302,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	600,000.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	600,000.00
2107	Томилолт, зочны зардал	774,800.00	703,600.00
210702	Дотоод албан томилолт	774,800.00	703,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	161,100.00	3,896,110.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	3,800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	71,100.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	50,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	46,110.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,087,761.51	1,550,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,087,761.51	1,550,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,361,960.19	45,420,298.67
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	15,750,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	15,750,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,000,000.00	9,590,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	6,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,000,000.00	2,990,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,361,960.19	20,080,298.67
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,361,960.19	20,080,298.67
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	0.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Архангай аймгийн Хотонт сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,234,000.00	75,264.04	7,359,681.21	9,668,945.25
2	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,225,975.35	-1,225,975.35
3	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,234,000.00	75,264.04	5,174,613.76	7,483,877.80
4	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,234,000.00	75,264.04	5,174,613.76	7,483,877.80
5	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-986,382.75	-986,382.75
6	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,234,000.00	75,264.04	4,188,231.01	6,497,495.05

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	198,162,200.00	178,081,901.33	20,080,298.67	89.87
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	198,162,200.00	178,081,901.33	20,080,298.67	89.87
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	172,812,200.00	152,741,901.33	20,070,298.67	88.39
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	141,268,100.00	123,644,171.28	17,623,928.72	87.52
210101	Үндсэн цалин	141,268,100.00	76,039,436.36	65,228,663.64	53.83
210102	Нэмэгдэл	-	42,685,234.92	(42,685,234.92)	
210104	Урамшуулал	-	4,919,500.00	(4,919,500.00)	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17,658,500.00	15,446,020.05	2,212,479.95	87.47
210201	Тэтгэврийн даатгал	12,007,800.00	10,516,564.64	1,491,235.36	87.58
210202	Тэтгэмжийн даатгал	1,412,700.00	1,229,216.49	183,483.51	87.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,130,100.00	943,487.35	186,612.65	83.49
210204	Ажилгүйдлийн даатгал	282,500.00	282,500.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,825,400.00	2,474,251.57	351,148.43	87.57
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,910,600.00	6,902,000.00	8,600.00	99.88
210401	Бичиг хэрэг	2,800,000.00	2,800,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	3,800,000.00	3,800,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	310,600.00	302,000.00	8,600.00	97.23
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	600,000.00	600,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	600,000.00	600,000.00	-	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	800,000.00	703,600.00	96,400.00	87.95
210702	Дотоод албан томилолт	800,000.00	703,600.00	96,400.00	87.95
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,025,000.00	3,896,110.00	128,890.00	96.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,800,000.00	3,800,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	85,000.00	-	85,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	50,000.00	40,000.00	55.56
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00	46,110.00	3,890.00	92.22
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,550,000.00	1,550,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,550,000.00	1,550,000.00	-	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	25,350,000.00	25,340,000.00	10,000.00	99.96
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	15,750,000.00	15,750,000.00	-	100.00

Архангай аймгийн Хотонт сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	15,750,000.00	15,750,000.00	-	100.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	9,600,000.00	9,590,000.00	10,000.00	99.90
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,600,000.00	6,600,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	2,990,000.00	10,000.00	99.67
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	198,162,200.00	178,081,91.33	20,080,298.67	89.87
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	198,162,200.00	178,081,91.33	20,080,298.67	89.87
132001	Орон нутгийн төсвөөс	198,162,200.00	178,081,91.33	20,080,298.67	89.87
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	Төсвийн байгууллага		1	0.00	100.00
3	АЖИЛЛАГСДЫН ТОО		3	0.00	100.00
4	Удирдах ажилтан		1	0.00	100.00
5	Гүйцэтгэх ажилтан		2	0.00	100.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар шилэн данс болон төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардалтай холбоотой 14,000.0 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар илэрсэн материаллаг зөрчлийн дүн нь **14,000.0** мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн **1,387.1** мянган төгрөгөөс их тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

**3.1.1** Тайлант онд сумын 21 төлөөлөгчид нийт 15,750.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд олгосон байна. Зарцуулалтыг харахад айл өрхөөр уулзалт хийж, мэдээлэл хүргэх шатахууны зардалд 1,750.0 мянга, өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой малын тарилга туулга, хивэг тэжээл худалдан авах, амьжиргааны түвшин доогуур айл өрхүүдэд гурил будаа зэрэг хүнсний бүтээгдэхүүний дэмжлэг үзүүлэхэд 14,000.0 мянган төгрөгийг зарцуулсан гэж тайлагнасан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор баталсан "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журамтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**3.1.2** Тайлант хугацаанд шилэн дансанд 11 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 7 дугаар зүйлийн 7.1.1-т "... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан шилэн дансны мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх үүргийг хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мян.төг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
			Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлыг журамд заасны дагуу зарцуулаагүй байна.	1	14,000.0	1	14,000.0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>14,000.0</b>	<b>1</b>	<b>0.0</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мян.төг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
			Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил				
Шилэн дансны системд мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан	1	0	1	0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>